

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН
ТООЦООНЫ ТАЙЛАН**

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН
ЭТГЭЭДЭД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**

ЗАХИАЛАГЧ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ГҮЙЦЭТГЭГЧ: СУДЛААЧ Л.ОТГОНДОРЖ

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

АГУУЛГА

Нэг. Ерөнхий мэдээлэл

Хоёр. Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

- 2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- 2.2. Нэг бүрийн зардлыг тооцох
- 2.3. Тоон үзүүлэлтийг тооцох
- 2.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах
- 2.5. Хялбарчлах боломжийг шалгах
- 2.6. Нэмэлт зардлыг тооцох

Гурав. Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо

- 3.1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох
- 3.2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- 3.3. Тоон үзүүлэлтийг тооцох
- 3.4. Нийт дүнг тооцож гаргах
- 3.5. Хялбарчлах боломжийг шалгах
- 3.6. Нэмэлт зардлыг тооцох

Дөрөв. Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

- 4.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох
- 4.2. Чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох
- 4.3. Гарах зардлыг тооцох
- 4.4. Зардлыг нэгтгэн тооцох
- 4.5. Хувилбарыг нягталж, зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх

Тав. Дүгнэлт

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

**/Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд
гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл/**

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн үйлчлэлд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “**аргачлал**” гэх/-ыг баримтлан доорх зардлын тооцоог хийв.

Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах болон бууруулах талаар санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү тайлангийн зорилго чиглэгдэх болно.

Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр төр, иргэн, хуулийн этгээдэд оногдуулж буй үүрэг тус бүрд зардал тооцогдох болно.

Хуулийн төсөл нь “шинэчилсэн найруулга” хэлбэрээр бичигдэж байгаа тул хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр болон өмнө гүйцэтгэж байсан үүргээс өргөжүүлсэн чиг үүргийн хүрээнд үнэлгээг хийх бөгөөд зөвхөн шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд хандан өргөдөл, гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахад оршино.” гэж заажээ. Мөн төслийн 3

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

дугаар зүйлийн 3.2-т “Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг уг хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.”, 3.4 дэх хэсэгт Тухайлсан хуулийн дагуу гаргасан өргөдөл, гомдлыг тухайн хуульд заасан журмаар шийдвэрлэх бөгөөд тухайн хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуульд заасны дагуу зохицуулна.” гэж заасан байна.

Харин хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1-д дараах харилцаанд үйлчлэхгүй байхаар тус тус заасан байна. **Үүнд:**

- Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Арбитрын тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар шийдвэрлэвэл зохих өргөдөл, гомдолд хамаарахгүй гэж заасан.

Хуулийн төслийн зохицуулалтыг судалж үзэхэд хүн, хуулийн этгээд нь өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл өргөдөл гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болохоор байгаа бөгөөд энэхүү тохиолдолд өргөдөл, гомдлоо цахим гарын үсгээр баталгаажуулах шаардлага тавьж байна. Ингэснээрээ иргэн, хуулийн этгээдэд шууд хүлээлгэсэн үүрэг бүхий зохицуулалт агуулж байгаа тул тухайн зохицуулалттай холбоотой зардал үүсэх эсэхийг тооцоолох хэрэгтэй байна.


Мөн төсөл нь төрийн байгууллага, албан тушаалтан буюу “төр”, мөн “нийтийн эрх зүйн этгээд” гэсэн зардал тээгч хоёр субъектэд үүрэг үүсгэсэн зохицуулалт агуулсан буюу тэдгээрт зардал үүсгэхээр харагдаж байна.

ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ЭТГЭЭДЭД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Энэхүү тооцооны аргачлалаар хуулийн этгээд төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд өргөдөл гомдлыг цахимаар гаргахтай холбоотойгоор хуулийн төсөлд тусгагдсан заавал гүйцэтгэх үүрэг буюу цахим гарын үсэг авах үүргийг хэрэгжүүлэхэд тухайн хуулийн этгээдээс гарах захиргааны зардлыг тооцох юм.


Өөрөөр хэлбэл хуульд заасан үүргийг хэрэгжүүлэхэд тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь ямар, ямар үйл ажиллагаа явуулах вэ?, түүнд дунджаар хэдий хэр цаг хугацаа зарцуулах вэ? Үүний цаана ямар хэмжээний мөнгөн зардал гарах вэ? гэдгийг тооцож гаргана.

Дээрх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. **Үүнд:**



2.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Хамгийн эхний алхам бол хуулийн төслөөс хуулийн этгээдийн гүйцэтгэх зардал бий болгох үүргийг тогтоох үе шат бөгөөд үүнийг дараах дарааллын дагуу гүйцэтгэнэ.



- Yүрэг болгосон эрх зүйн зохицуулалтыг хуулийн төслөөс тодорхойлон тогтоох,
- Yүргийн агуулга нэг бүрийг тодорхойлох;
- Yүрэг гүйцэтгэх хуулийн этгээдийн тоог тодорхойлж гаргана.

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг гэдэгт тоо баримт, тайлан, бусад мэдээллийг төрийн байгууллага буюу **гуравдагч этгээдэд** бэлтгэж өгөх, хүргүүлэх, бэлэн байлгах, аливаа төрлийн зөвшөөрөл, лиценз авах зэргийг хамааруулан ойлгоно.

Дээр дурдсан утгаар хуулийн төсөл нь дараах төрлийн үүргийг хуулийн этгээдэд оногдуулсан байна. **Үүнд:**

1. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” буюу хуулийн этгээд нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд заавал цахим гарыг үсгээр баталгаажуулсан байхыг шаардсан байна.

Дээрх үүргийг биелүүлэхэд хуулийн этгээдэд үүсэх захиргааны болон бодит зардлыг тооцоолох болно. Энэхүү зардлын тооцоо нь хуулийн этгээдийн зүгээс цахим гарын үсэг авахтай холбоотой гарах зардлыг тооцоолохоос, тухайн өргөдөл гомдлыг гаргахтай холбоотой бусад цаг хугацаа болон зардлыг тооцохгүй болно.


Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, түүний агуулгыг гаргасан байдал

| д/д | Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг | Үүргийн агуулга | Тайлбар |
|------------|--|--|---|
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | Цахим хэлбэрээр өргөдөл, гомдол гаргах үед цахим гарын үсгээр баталгаажуулах. Цахим гарын үсгээр өргөдөл, гомдол баталгаажуулахын тулд цахим гарын үсэгтэй болох. | Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг удирдлага болгов. |

2.2.НЭГ БҮРИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ шатанд өмнө нь тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах захиргааны мөнгөн зардлыг цаг хугацаагаар дамжуулан тооцоолон гаргах юм. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. **Үүнд:**

² Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т “цахим гарын үсэг” гэж цахим мэдээлэлд гарын үсэг зурсан, цахим тамга хэрэглэсэн этгээдийг тодорхойлох зорилгоор мэдээлэл хавсаргасан, эсхүл нэгтгэсэн цахим өгөгдлийг” ойлгохоор заасан.



Үүрийг гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг **стандарт үйл ажиллагаа** гэж аргачлалд заасан бөгөөд үүрэг тус бүр өөр өөрийн онцлогтой, тэдгээртэй холбогдуулан хийх үйлдэл ялгаатай байх боловч нийтлэг байдлаар ихэнх үүрэгт олон давтамжтай хийгддэг ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аргачлалд “Стандарт үйл ажиллагаа”-ны жагсаалтыг гаргасан байдаг.

| Д/д | Гүйцэтгэх үүрэг | Мэдээллийн агуулга | Стандарт үйл ажиллагаа | Хугацаа |
|-----|--|---|---|-----------------|
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | Цахим гарын үсгээр өргөдөл, гомдол баталгаажуулахын тулд цахим гарын үсэгтэй болох. | Цахим гарын үсэг авахаар бүртгэлийн байгууллагад очих. ³ | 20 минут |
| | | | Цахим гарын үсэг авах анкет бөглөх. | 5 минут |
| | | | Албан бичиг бичиж өгөх | 5 минут |
| | | | Итгэмжлэл бэлтгэж өгөх | 5 минут |
| | Нийт зарцуулах хугацаа (дээрх үүргийг нэг удаа хэрэгжүүлэхэд хуулийн этгээдийн зарцуулах дундаж хугацаа) | | | 35 минут |

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа ажилтанд олгох сарын дундаж үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цагаар гаргана.

Цалин хөлстэй холбоотой статистикт Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас болох www.1212.mn байршуулсан судалгааг эх сурвалж болгох юм.

³ Энэхүү үүрэг нь зөвхөн цахим гарын үсэг аваагүй иргэдэд хамаарах бөгөөд цахим гарын үсэг авсан иргэд нь өөрийн цахим гарын үсгээр өргөдөл, гомдлоо баталгаажуулна.

“Дундаж цалин хөлс гэдэгт тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.” гэж статистикт үздэг байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар⁴ “2022 оны 4 дүгээр сарын байдлаар аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа бизнесийн байгууллагын оффисын дундаж ажилтан буюу захиргааны ажилтан сард дундажаар 1.574.0 төгрөгийн цалин хөлс авч байгааг судалгаанд дурдсан байна. Иймд хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой ажлын хөлсийг тооцоолохдоо Үндэсний статистикийн хорооноос гаргасан дээрх судалгааг эх сурвалж болгон ашиглах юм.

Ажиллах хугацааг гаргахдаа Хөдөлмөрийн тухай хуульд⁵ заасан ажлын цагийг баримтлав.

| |
|---|
| Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа |
| 1.574.000 ⁶ : 22 ⁷ өдөр : 8 ⁸ цаг = 8943 төгрөг /оффисын захиргааны нэг ажилтны ажлын нэг цагт ноогдох дундаж хөдөлмөрийн хөлс/ |

Хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон ажлын хөлс тодорхой болсон тул нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа захиргааны зардлыг тухайн үүргийг гүйцэтгэхэд зарцуулж буй “хугацаа”-г “ажлын хөлс”-өөр үржүүлэх замаар доор гаргав.

| Д/Д | Гүйцэтгэх үүрэг | Зарцуулах хугацаа | Ажлын хөлс /цагаар/ | Нэг аж ахуйн нэгжийн зардал |
|-----|--|-------------------|---------------------|-----------------------------|
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | 35 минут | 8,943 төгрөг | 5,365 төгрөг |

⁴ http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=average_wage_2017.pdf&ln=Mn /Үндэсний статистикийн хорооны албан ёсны веб хуудаст байршуулсан цалин хөлсний талаарх судалгаа

⁵ Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйл.

⁶ Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2022 оны 1 дүгээр улирлын байдлаарх сарын дундаж цалин хөлс

⁷ Хөдөлмөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан 7 хоногийн 5 өдөр ажиллах тул сард дундажаар 22 ажлын өдөр байдаг болно.

⁸ Хөдөлмөрийн тухай хуульд заасан 1 ажлын өдөрт ажиллах цаг

2.3. ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ:

Энэ үе шатанд хуулиар оногдуулсан үүргийг хэдэн хуулийн этгээд, хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм. Өөрөөр хэлбэл хуулийн төсөл үйлчлэлд нь хамаарч буй нийт хуулийн этгээдэд ямар зардал үүсгэж байгааг тооцох юм.

Хуулийн төсөлд тусгагдсанаар цахим гарын үсгийг зөвхөн цахимаар өргөдөл, гомдол гаргасан тохиолдолд хэрэглэхээр заасан байна. Зардлын тооцоо нь зардал, ачааллыг нэг жилээр тооцдог тул хуулийн төсөлд тусгагдсан цахим гарын үсэг авах үүргийг нэг хуулийн этгээд зөвхөн нэг л удаа гүйцэтгэх юм.

Тоон үзүүлэлтийг гаргахын тулд **тохиолдлын тоо**⁹ болон **давтамжийг**¹⁰ холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

Тоон үзүүлэлт нь хуулийн үйлчлэлд хамаарах бүх хуулийн этгээдэд үүсэх нийт зардлыг тооцоолоход ашиглах ач холбогдол бүхий тоон утга юм. Үүнийг дараах томъёогоор гаргана.

| |
|---|
| ТОХИОЛДЛЫН ТОО х ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ |
|---|

Дээрх томъёоны дагуу тоон үзүүлэлтийг тогтоохын тулд тохиолдлын тоо буюу хэдэн хуулийн этгээд уг үүргийг хэрэгжүүлэх вэ гэдэг тоо зайлшгүй шаардлагатай байна.

Тухайлбал 2021 онд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийт 641,318 иргэн хандаж өргөдөл, гомдол, санал, шүүмжлэл гаргаснаас 629,678 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 98,1 хувийн үзүүлэлттэй байна.¹¹ Энэхүү тоо баримтаас үзэхэд иргэн болоод хуулийн этгээдийн гаргасан өргөдөл гомдлыг иргэний гаргасан өргөдөл, гомдол гэх байдлаар бүртгэж байгаа харагдаж байна. Учир нь хуулийн этгээдээс хандаж гаргасан өргөдөл, гомдол гэх ангиллаар гаргасан судалгаа албан ёсоор хийгдээгүй байна. Харин Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандсан нийт өргөдөл гомдлын 1063 нь цахимаар, Засгийн газрын гишүүд, яам, агентлагт хандаж гаргасан өргөдөл гомдлын 69,585 нь цахимаар, Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын 23,579 нь цахимаар буюу нийт 94,227 өргөдөл гомдлыг цахим хэлбэрээр гаргасан тооцоо судалгаа байна. Иймд судлаачын хувьд тус цахим өргөдөл, гомдлын тал хувийг хуулийн этгээдийн тохиолдлыг тоо болгоход баримжаа болгон ашиглахаар шийдлээ.

⁹ “Тохиолдлын тоо” гэдэг нь тухайн шинээр бий болж байгаа үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлэх тоог ойлгоно.

¹⁰ “Давтамж” гэдэг нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллага үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлэх тоо юм.

¹¹ <https://cabinet.gov.mn/6818.html>

Энэхүү тохиолдлын тоо буюу 94,227 цахимаар гаргасан өргөдөл гомдол нь тухайн жилд гаргаж буй нийт өргөдөл гомдлын 14,6 хувийг эзэлж байна.

Тэгэхээр төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс гомдол гаргалаа гэж үзэхэд түүний 14,6 хувь нь цахимаар өргөдөл, гомдлоо гаргах магадлалтай байна гэж үзэж болохоор байна.

Монголын Үндэсний статистикийн хорооноос гаргасан тоон мэдээллээр 2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт 81,533¹² аж ахуйн нэгж, байгууллага байна. Эдгээр байгууллага явуулж буй үйл ажиллагаатайгаа холбоотой төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргалаа гэж үзэхэд 14,6 хувь буюу 11,903 аж ахуйн нэгж байгууллага нь цахимаар өргөдөл, гомдлоо гаргах магадлалтай байна гэж үзлээ.

| Д/Д | Гүйцэтгэх үүрэг | Тохиолдлын тоо | х | Давтамж | = | Тоон үзүүлэлт |
|-----|--|----------------|---|-------------------|---|---------------|
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | 11,903 | х | 0,5 ¹³ | = | 5,951 |

2.4. НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ДҮНГ ТООЦОЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд хуулийн төслийн дагуу шинээр хүлээсэн үүргийг хуулийн төслийн үйлчлэлд хамаарах нийт хуулийн этгээд гүйцэтгэхэд ямар хэмжээний захиргааны зардал гарах вэ гэдгийг “нэг бүрийн зардал”-ыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлэх замаар тооцоолох юм. Үүнийг томъёогоор илэрхийлвэл:

НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ х ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ

| Д/Д | Гүйцэтгэх үүрэг | Нэг | х | Тоон | = | Нийт |
|-----|-----------------|-----|---|------|---|------|
|-----|-----------------|-----|---|------|---|------|

¹² <https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/47812001> Монголын Үндэсний статистикийн хорооноос эмхлэн гаргадаг Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2021, 732 дахь тал

¹³ Цахим гарын үсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Гэрчилгээг Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд таван ... жилийн хугацаагаар олгоно.” гэж заасан тул давтамж нь 0,5 байхаар тодорхойлов. Өөрөөр хэлбэл хуулийн этгээд нь нэг удаа цахим гарын үсэг авсан тохиолдолд 5 жилийн дотор цахимаар гаргаж буй өргөдөл гомдолдоо тухайн гарын үсгээ ашиглах болно.

| | | бүрийн зардал | | үзүүлэлт | | зардал ¹⁴ |
|--------------------|--|---------------|---|----------|---|----------------------|
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | 5,365 | х | 5,951 | = | 31,927,115 |
| Нийт зардал | | | | | | 31,927,115 |

2.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР:

Нэг хуулийн этгээдэд үүсэх зардал нь төдийлөн их биш учраас хуулийн этгээд нь энэхүү үүргийг гүйцэтгэхийн тулд шинээр хүн нэмж авахгүйгээр шийдвэрлэх боломжтой байна.

2.6.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ:

Хуулийн төсөлд тусгагдсан үүргийг хуулийн этгээд биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хууль тогтоомжоор тогтоосон төлбөр хураамж, шинээр худалдан авах шаардлагатай тоног төхөөрөмж, материал зэрэгтэй холбогдон үүсч, шууд гарах зардлыг **нэмэлт зардал** гэсэн ойлголтод хамруулж ойлгодог болно.

Хуулийн төсөлд зааснаар аж ахуйн нэгж нь цахим хэлбэрээр гаргасан өргөдөл гомдол нь цахим гарын үсгээр баталгаажуулахыг шаардаж байгаа. Тухайн цахим гарын үсгийг хуулийн этгээд нэг удаа авах үнэлгээ нь 35,000 төгрөг¹⁵ байгаа нь судалгааны явцад тогтоогдсон болно. Иймд нэмэлтээр цахим хэлбэрээр өргөдөл, гомдол гаргаж байгаа хуулийн этгээдэд зөвхөн нэг удаа нэмэлтээр дунджаар 35,000 төгрөгийн нэмэлт зардал гарахаар байгаа бөгөөд энэ нь байж болох зардал гэж үзлээ.

¹⁴ “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

¹⁵ Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.3-т “тоон гарын үсэг” гэж энэ хуулийн 6.2-т заасан шаардлагыг хангасан цахим гарын үсгийг, 4.1.4-т “тоон гарын үсгийн гэрчилгээ” гэж тоон гарын үсгийн нийтийн түлхүүртэй давтагдашгүй байдлаар холбогдсон хүн, хуулийн этгээдэд тоон гарын үсэг хэрэглэх эрхийг олгосон цахим баримт бичгийг, гэж заасан бөгөөд тус хуулийн 12.2-т “Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд олгох тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг иргэний үнэмлэхийг санах ойд байршуулахад энэ хуулийн 12.1 дэх хэсэг хамаарахгүй” буюу гэрчилгээг үнэ төлбөргүй олгохоор заасан байна.

ГУРАВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ЭТГЭЭДЭД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдсанаар иргэнд хүлээлгэсэн үүрэгтэй холбоотойгоор тухайн үүргийг гүйцэтгэсний улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргах болно.

Ийнхүү үүсэх зардлыг аргачлалын 3 дугаар зүйлийн, 3.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно:

Үүнд:

- Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- Тоон үзүүлэлтийг тооцох;
- Нийт дүнг тооцож гаргах;
- Хялбарчлах боломжийг шалгах

3.1.ИРГЭНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛОХ

Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд зааснаар иргэн шинээр нэмж дараах үүргийг хүлээж байна. **Үүнд:**

2. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” буюу хүн нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд заавал цахим гарыг үсгээр баталгаажсан байхыг шаардсан байна.

1995 онд батлагдсан Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д 2003 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт, 2009 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан байх бөгөөд тус зүйлд “Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар гаргана. Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно. Байгууллага бүр цахим хаягтай байна.” гэж заасан байна. Энэхүү зохицуулалт дээр шинэчилсэн найруулгаар цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол цахим гарын үсгээр баталгаажсан байх шаардлагыг шинээр тусгажээ.

Дээрх тодорхойлсон үүргийн мэдээллийн агуулгыг хуулийн төсөлд болон бусад хууль тогтоомжид заасан зохицуулалтад үндэслэн дор дурдсан байдлаар тогтоов. Мэдээллийн агуулга гэдэгт гүйцэтгэх үүрэг тухайн үүргийг хүлээж буй

иргэнээс тодорхой мэдээллийг төрийн байгууллага болон гуравдагч этгээдэд бэлтгэж өгөх, бэлэн байлгах болон хүргүүлэхийг буюу хүсэлтэд хавсаргахаар хууль, журамд заасан баримт бичиг, мэдээллийн бүрдлийг хамруулан ойлгох юм.

Иргэний гүйцэтгэх үүрэг, түүний агуулгыг гаргасан байдал

| д/д | Иргэний гүйцэтгэх үүрэг | Үүргийн агуулга | Тайлбар |
|-----|--|--|---|
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр ¹⁶ баталгаажсан байна.” | Цахим хэлбэрээр өргөдөл, гомдол гаргах үед цахим гарын үсгээр баталгаажуулах. Цахим гарын үсгээр өргөдөл, гомдол баталгаажуулахын тулд цахим гарын үсэгтэй болох. | Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг удирдлага болгов. |

3.2.ЦАГ ХУГАЦАА БОЛОН ГАРЧ БОЛОХ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ үе шатанд:

- Иргэний гүйцэтгэх үүргийн агуулга, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай стандарт ажиллагааг тогтоох;
- Уг стандарт ажиллагаанд зарцуулах хугацааг тодорхойлох;
- Тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс зайлшгүй гарах мөнгөн зардлыг тооцно.

Өмнөх шатанд тодорхойлсон үүрэг, түүний агуулгыг бүрдүүлэхэд иргэнээс зарцуулах хугацааг бодит нөхцөл байдалд тулгуурлан ердийн дундаж хугацаагаар баримжаалан гаргасан болно.

| Д/д | Гүйцэтгэх үүрэг | Мэдээллийн агуулга | Стандарт үйл ажиллагаа | Хугацаа |
|-----|---|---|--|----------|
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт | Цахим гарын үсгээр өргөдөл, гомдол баталгаажуулахын тулд цахим гарын үсэгтэй болох. | Цахим гарын үсэг авахаар бүртгэлийн байгууллагад очих. ¹⁷ | 20 минут |
| | | | Цахим гарын үсэг авах | 5 минут |

¹⁶ Цахим гарын үсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т “цахим гарын үсэг” гэж цахим мэдээлэлд гарын үсэг зурсан, цахим тамга хэрэглэсэн этгээдийг тодорхойлох зорилгоор мэдээлэл хавсаргасан, эсхүл нэгтгэсэн цахим өгөгдлийг” ойлгохоор заасан.

¹⁷ Энэхүү үүрэг нь зөвхөн цахим гарын үсэг аваагүй иргэдэд хамаарах бөгөөд цахим гарын үсэг авсан иргэд нь өөрийн цахим гарын үсгээр өргөдөл, гомдлоо баталгаажуулна.

| | | | |
|--|---|---------------|-----------------|
| хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | | анкет бөглөх. | |
| Нийт зарцуулах хугацаа (дээрх үүргийг нэг удаа хэрэгжүүлэхэд иргэний зарцуулах дундаж хугацаа) | | | 25 минут |
| Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс гарах мөнгөн дүнээр илэрхийлэгдэх шууд зардал | Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх зардлын хэмжээ шууд | | |
| Цахим гарын үсгийн үнэ | Үнэгүй ¹⁸ | | |

Тоон үзүүлэлтийг тооцож гаргах:

Өмнөх хэсэгт хуулийн төслөөр иргэнд шинээр гүйцэтгэхээр болж байгаа үүргийг хэдэн иргэн, жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг энэ үе шатанд тооцоолон гаргана.

Тоон үзүүлэлтийг тохиолдлын тоо буюу уг үүргийг хэдэн иргэн гүйцэтгэх ёстойг, давтамжийн тоо буюу дээрх иргэдэд уг үүргийг жилд хэдэн удаа давтан гүйцэтгэхээр заасан байгаа вэ гэсэн үзүүлэлтээр тодорхойлох болно.

2021 онд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийт 641,318 иргэн хандаж өргөдөл, гомдол, санал, шүүмжлэл гаргаснаас 629,678 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 98,1 хувийн үзүүлэлттэй байна.¹⁹ Энэхүү тоо баримтаас үзэхэд иргэн болоод хуулийн этгээдийн гаргасан өргөдөл гомдлыг иргэний гаргасан өргөдөл, гомдол гэх байдлаар бүртгэж байгаа харагдаж байна. Учир нь хуулийн этгээдээс хандаж гаргасан өргөдөл, гомдол гэх ангиллаар гаргасан судалгаа албан ёсоор хийгдээгүй байна. Харин Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандсан нийт өргөдөл гомдлын 1063 нь цахимаар, Засгийн газрын гишүүд, яам, агентлагт хандаж гаргасан өргөдөл гомдлын 69,585 нь цахимаар, Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын 23,579 нь цахимаар буюу нийт 94,227 өргөдөл гомдлыг цахим хэлбэрээр гаргасан тооцоо судалгаа байна.

¹⁸ Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.3-т “тоон гарын үсэг” гэж энэ хуулийн 6.2-т заасан шаардлагыг хангасан цахим гарын үсгийг, 4.1.4-т “тоон гарын үсгийн гэрчилгээ” гэж тоон гарын үсгийн нийтийн түлхүүртэй давтагдашгүй байдлаар холбогдсон хүн, хуулийн этгээдэд тоон гарын үсэг хэрэглэх эрхийг олгосон цахим баримт бичгийг, гэж заасан бөгөөд тус хуулийн 12.2-т “Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд олгох тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг иргэний үнэмлэхийг санах ойд байршуулахад энэ хуулийн 12.1 дэх хэсэг хамаарахгүй” буюу гэрчилгээг үнэ төлбөргүй олгохоор заасан байна.

¹⁹ <https://cabinet.gov.mn/6818.html>

Иймд судлаачын хувьд тус цахим өргөдөл, гомдлын тал хувийг иргэдийн зүгээс гаргаж байгаа өргөдөл, гомдлын тохиолдлыг тоо болгоход баримжаа болгон ашиглахаар шийдлээ. Энэхүү тохиолдлын тоо буюу 94,227 цахимаар гаргасан өргөдөл гомдол нь тухайн жилд гаргаж буй нийт өргөдөл гомдлын 14,6 хувийг эзэлж байна. Үүний тал хувь нь 47,113 нь иргэдийн зүгээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд иргэдийн зүгээс цахимаар гаргаж байгаа өргөдөл гомдлын тоо гэж үзэж болохоор байна.

Тэгэхээр төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс гомдол гаргалаа гэж үзэхэд түүний 14,6 хувь нь цахимаар өргөдөл, гомдлоо гаргах магадлалтай байна гэж үзэж болохоор байна.

ТООН ҮЗҮҮЛЭЛТ = ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖИЙН ТОО

Дээрх томъёогоор тоон үзүүлэлтийг тооцож гаргах болно.

| Д/Д | Гүйцэтгэх үүрэг | Тохиолдлын тоо | x | Давтамжийн тоо | = | Тоон үзүүлэлт |
|-----|--|----------------------|---|-------------------|---|---------------|
| | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | 47,113 ²⁰ | x | 0,5 ²¹ | = | 23,556 |

3.3.НИЙТ ДҮНГ ТООЦООЛЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд хуулийн төслийн хүрээнд иргэнд шинээр бий болсон үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тэдэнд үүсэх ачааллыг цаг хугацаагаар тооцоолон гаргана. Иргэнд үүсэх ачаалал нь өмнөх үе шатуудад тооцоолон гаргасан цаг хугацааны зарцуулалтыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр тодорхойлогдоно.

АЧААЛАЛ=ЦАГ ХУГАЦААНЫ ЗАРЦУУЛАЛТ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ

²⁰ <https://cabinet.gov.mn/6818.html> 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай Монгол Улсын ЗГХЭГ-ын албан ёсны мэдээллээс цахим хэлбэрээр гаргасан өргөдөл гомдлын тоонд үндэслэв.

²¹ Цахим гарын үсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Гэрчилгээг Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд таван ... жилийн хугацаагаар олгоно.” гэж заасан тул давтамж нь 0,5 байхаар тодорхойлов. Өөрөөр хэлбэл хуулийн этгээд нь нэг удаа цахим гарын үсэг авсан тохиолдолд 5 жилийн дотор цахимаар гаргаж буй өргөдөл гомдолдоо тухайн гарын үсгээ ашиглах болно.

| ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНИЙ ЗҮГЭЭС ХУУЛЬД ЗААСАН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ҮҮСЭХ ЦАГ ХУГАЦААНЫ АЧААЛАЛ | | | | | | |
|---|--|--------------------------|----------|----------------------|----------|---|
| Д/д | Гүйцэтгэх үүрэг | Зарцуулах хугацаа | x | Тоон үзүүлэлт | = | Иргэнд үүсэх цаг хугацааны ачаалал |
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | 25 минут | x | 23,556 | = | 588,900 |
| Нийт | | | | | | 588,900 минут буюу 9,815 цаг |

| ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНИЙ ЗҮГЭЭС ХУУЛЬД ЗААСАН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ҮҮСЭХ МӨНГӨН ЗАРДАЛ | | | | | | |
|---|--|----------------------|----------|----------------------|----------|---------------------------|
| Д/д | Гүйцэтгэх үүрэг | Тоон үзүүлэлт | x | Мөнгөн зардал | = | Нийт мөнгөн зардал |
| 1 | Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Хүн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо тухайн байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаягт хандан, эсхүл энэ хуулийн 14.8-д заасан өргөдөл, гомдлын нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргаж болно. Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдол нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” | 23,556 | x | 0 | = | 0 төгрөг |
| Нийт | | | | | | 0 төгрөг |

3.4.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙГ ШАЛГАХ:

Хуулийн төслөөр иргэнд шинээр бий болгосон 1 үүрэг байна гэж тодорхойлов. Бусад үүргүүдийн тухайд өмнө практикт хэрэгжүүлж байсан бөгөөд хуулийн төсөлд тодорхойлох замаар тусгасан гэж үзлээ.

Хуулийн төслөөс иргэнд үүсэх зардлын тооцооны судалгаагаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу иргэдэд үүсч байгаа үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс шаардагдах мөнгөн болон цаг хугацааны ачааллыг тооцсон болно.

Тооцооллыг гаргахдаа хуулийн төслөөр иргэнд шинээр бий болгосон үүргийг хэрэгжүүлэхийн тулд иргэнээс шаардсан баримт бичиг, тус үүргийг биелүүлэхэд иргэний гүйцэтгэх үйл ажиллагааг нэг бүрчлэн гаргах замаар цаг хугацааг тооцлоо. Мөнгөн зардлыг тооцохдоо Цахим гарын үсгийн тухай хуулийг эх сурвалж болгон ашигласан болно.

Иргэнээс тухайн үүрэгт хамааралгүй бичиг баримт шаардсан тохиолдолд байхгүй бөгөөд үүсгэж байгаа цаг хугацааны ачаалал нь байж болох хэмжээнд байна гэж үзлээ. Тус хуулийн төслөөр иргэнд мөнгөн зардал үүсэхээргүй байна.


3.5.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ:

Тус хуулийн төслөөр иргэнд үүсэх нэмэлт зардал байхгүй тул тооцох шаардлагагүй гэж үзлээ.

ДӨРӨВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл нь төрийн аль байгууллагад шинээр үүрэг бий болгож, үүнийг дагалдан тухайн төрийн байгууллагад ямар зардал үүсэх вэ гэдгийг энэ хэсэгт тооцоолох юм. Төрийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг дараах үе шатын дагуу тооцоолно.

Үүнд:



4.1.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛОХ

Хуулийн төсөлд зааснаар дараах байгууллагууд шинээр нэмж үүрэг хүлээж байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.8-д “өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээг тогтмол хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх”;
2. Хуулийн төслийн 8.1.9-д “өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, шийдвэрийн хэрэгжилтийн талаар харьяа байгууллага, доод шатны албан тушаалтны авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтэд хяналт тавих”;
3. Хуулийн төслийн 8.1.10-д “хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг олон нийтэд мэдээлж, сурталчлах”;
4. Хуулийн төслийн 8.2-т “Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээд энэ хуулийн 8.1.10-т заасан мэдээлэх үүргийг иргэд, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын тайлбар, зааварчилгааг сонсох, үзэх боломжтой болон бусад хэлбэрээр өөрийн цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд нээлттэй мэдээлнэ”;
5. Хуулийн төслийн 8.3-т “Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээд энэ хуулийн 8.1.13-т заасан санал, дүгнэлтийг өргөдөл, гомдлын агуулгад хийсэн судалгаанд үндэслэн боловсруулна”;
6. Хуулийн төслийн 13.1-д “Төрийн байгууллага, нийтийн эрх зүйн этгээд нь өргөдөл, гомдол хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтан, нэгж ажиллуулах, эсхүл зохих албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод хяналт тавих чиг үүргийг тусгасан байна.”
7. Хуулийн төслийн 13.2-т “Аливаа хэлбэрээр ирсэн өргөдөл, гомдлыг энэ хуулийн 13.1-д заасан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу доор зааснаар ангилж, өргөдөл, гомдлын нэгдсэн системд бүртгэнэ”
8. Хуулийн төслийн 14.3-т “Иргэд олон нийттэй харилцах төв нь өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авах байр, өргөдөл, гомдол хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтантай байна.”
9. Хуулийн төслийн 14.6-д “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээг нэгтгэж өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж, өөрийн цахим хуудаст нээлттэй байршуулна.”
10. Хуулийн төслийн 14.8-д “Өргөдөл, гомдлын нэгдсэн системийн үйл ажиллагааг Иргэд олон нийттэй харилцах төв хариуцан зохион байгуулна.”

Эдгээр зохицуулалтаар төрийн байгууллага, албан тушаалтан үүрэг хүлээж байгаа нь харагдаж байна. Хуулийн төсөл нь шинэчилсэн найруулга хэлбэрээр бичигдэж байгаа бөгөөд 1995 онд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль

батлагдаж, 2003, 2009, 2015, 2016, 2017 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт орж байсан байна. Иймд тус хуульд байсан үүргүүд дээр шинэчилсэн найруулгаар төрийн байгууллага, албан тушаалтанд шинээр бий болгосон үүрэгтэй холбоотой зардлын тооцоо хийх нь зөв юм.

| Д/д | Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай |
|------------|--|--|
| 1 | 8.1.9.өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, шийдвэрийн хэрэгжилтийн талаар харьяа байгууллага, доод шатны албан тушаалтны авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтэд хяналт тавих; | 19.1. Төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд тухайн байгууллагын эрх баригч болон эрх бүхий албан тушаалтан хяналт тавина. |
| 2 | 8.1.10.хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг олон нийтэд мэдээлж, сурталчлах; | 7.1.8. өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн дагуу харьяа байгууллага, доод шатны албан тушаалтны авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг шалгах; |
| 3 | 8.2.Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээд энэ хуулийн 8.1.10-т заасан мэдээлэх үүргийг иргэд, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын тайлбар, зааварчилгааг сонсох, үзэх боломжтой болон бусад хэлбэрээр өөрийн цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд нээлттэй мэдээлнэ. | 9.1. Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр буюу амаар гаргана. Өргөдөл, гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно. Байгууллага бүр цахим хаягтай байна. |
| 4 | 8.3.Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээд энэ хуулийн 8.1.13-т заасан санал, дүгнэлтийг өргөдөл, гомдлын агуулгад хийсэн судалгаанд үндэслэн боловсруулна. | 20.1. Төрийн байгууллагууд өргөдөл, гомдлын агуулгад судалгаа дүгнэлт хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ. |
| 5 | 13.1.Төрийн байгууллага, нийтийн эрх зүйн этгээд нь өргөдөл, гомдол хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтан, нэгж ажиллуулах, эсхүл зохих албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод хяналт тавих чиг | 12.2. Иргэдийг хүлээн авах байранд ирж амаар гаргасан өргөдөл, гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий ажилтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ. 12.3. Бичгээр болон цахим |

| | | |
|--|--|---|
| | үүргийг тусгасан байна. | сүлжээгээр дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ. |
| | 13.2-т “Аливаа хэлбэрээр ирсэн өргөдөл, гомдлыг энэ хуулийн 13.1-д заасан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу доор зааснаар ангилж, өргөдөл, гомдлын нэгдсэн системд бүртгэнэ” | 12.2. Иргэдийг хүлээн авах байранд ирж амаар гаргасан өргөдөл, гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий ажилтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ. 12.3. Бичгээр болон цахим сүлжээгээр дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ. |

Мөн 2022 онд УИХ-аас баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Засгийн газар дахь хяналтын тухай хуульд зарим чиг үүрэг нь тусгагдсан байна.

| Д/д | Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ | Засгийн газар дахь хяналтын тухай хууль |
|------------|---|--|
| 1 | 8.1.8.өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээг тогтмол хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх; | 9.1. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар энэ хуулийн 5.1-д заасан асуудлаар хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ байгууллага, албан тушаалтнаас тайлан, мэдээллийг гаргуулан авна. |
| 2 | 14.3 Иргэд олон нийттэй харилцах төв нь өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авах байр, өргөдөл, гомдол хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий ажилтантай байна. | 18.1. Хүн, хуулийн этгээдийн энэ хуулийн 5.1-д заасан асуудлаар бичгээр болон бусад хэлбэр, цахим шуудангаар, эсхүл Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төвөөр дамжуулан гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ. |
| | 14.6 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээг нэгтгэж өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих асуудал хариуцсан төрийн захиргааны | 8.1. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хүн, хуулийн |

| | | |
|--|---|---|
| | байгууллагад улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж, өөрийн цахим хуудаст нээлттэй байршуулна. | этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, шүүхийн шийдвэр, энэ хуулийн 3.2.1-д заасан байгууллагын шийдвэр, хэрэглэгчийн үнэлгээний судалгаа зэргийг үндэслэн тандалт судалгаа хийнэ. 9.1. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар энэ хуулийн 5.1-д заасан асуудлаар хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ байгууллага, албан тушаалтнаас тайлан, мэдээллийг гаргуулан авна. |
|--|---|---|

Дээрх хүснэгтэд байгаа хуулийн зохицуулалтууд нь өмнөх хууль болон 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэг дагаж мөрдөх Засгийн газар дахь хяналтын тухай хуульд агуулгаараа орсон байгаа тул зардал тооцох боломжгүй юм. Өөрөөр хэлбэл тухайн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт болон анхдагч хуулийн төсөл батлахтай холбоотой зардлын тооцоонд орсон гэж үзэж байна.

Иймд дараах заалтуудтай холбогдуулан шинээр нэмж үүрэг хүлээж байна.

Үүнд:

1. Хуулийн төслийн 14.8-д “Өргөдөл, гомдлын нэгдсэн системийн үйл ажиллагааг Иргэд олон нийттэй харилцах төв хариуцан зохион байгуулна.” Буюу иргэд олон нийттэй харилцах төв.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т “Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж удирдах үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүлээнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2005 оны “Өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолоор төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой зарим асуудлыг зохицуулж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, тусгай утас болон бусад сувгаар иргэдээс санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, лавлагаа мэдээллээр иргэдэд үйлчилж байна. Мөн “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 187 дугаар тогтоолд заасны дагуу иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах төрийн байгууллагын дуудлагын утсыг нэгтгэх болон

цахимаар хүлээн авах техникийн шинэчлэл хийх, хяналт тавих албан тушаалтныг системд бүртгэх, үүрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой заажээ.

Тус системд одоогийн байдлаар 75 төрийн байгууллага болон холбогдсон бөгөөд тус төвийн программын хэрэглэгч талуудад төрийн байгууллага, оператор, иргэн, төрийн байгууллагын удирдлага болон тухайн байгууллагын дээд шатны удирдлага багтахын зэрэгцээ тухай бүр шаардлагатай тайлан, мэдээллээр Засгийн газар, яам, агентлагуудыг хангаж байна.²² Өөрөөр хэлбэл хуулийн төслийн 14.8-д “Өргөдөл, гомдлын нэгдсэн системийн үйл ажиллагааг Иргэд олон нийттэй харилцах төв хариуцан зохион байгуулна.” гэж заасан өргөдөл, гомдлын нэгдсэн систем нь одоогийн Иргэд олон нийттэй харилцах төвд ашиглаж буй программ хангамж байгаа нь харагдаж байна.

Иймд хуулийн төслийн дээрх зохицуулалтаар шинээр өргөдөл, гомдлын нэгдсэн системтэй болох асуудал бус одоо байгаа системдээ бүртгэлтэй байгаа 75 төрийн байгууллагаас бусад төрийн байгууллагыг нэгтгэхтэй холбоотой харилцааг зохицуулжээ. Өөрөөр хэлбэл 2020 оны байдлаарх Төрийн захиргааны төв байгууллага-14, Төрийн захиргааны байгууллага-36, УИХ-ын дэргэдэх байгууллага, зөвлөл, хороо-14, Нутгийн өөрөө удирдах байгууллага-21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, нийслэлийн ИТХ, Засаг дарга болон Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг-34, Төрийн өмчит их дээд сургууль, эмнэлэг, бусад-29, нийт 489 төрийн байгууллагаас үлдсэн 414 төрийн байгууллагыг тус системд нэгтгэхтэй холбоотой харилцаа үүсэхээр байна. Тэгэхээр хуулийн төслийн 14.8-д “Өргөдөл, гомдлын нэгдсэн системийн үйл ажиллагааг Иргэд олон нийттэй харилцах төв хариуцан зохион байгуулна.” гэсэн зохицуулалттай холбоотой цаашид “Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох”, “Гарах зардлыг урьдчилан тооцоолох” алхмуудыг хийх боломжгүй гэж үзлээ. Учир нь энэхүү харилцаа нь хүний нөөцийг тодорхойлох, ажлын байрны зардал, шаардлагатай техник хэрэгслийн зардлаар тооцогдох бус тус системийн хөгжүүлэлтийг хийх аж ахуйн нэгжүүдийн үнэлгээнээс харилцан хамааралтай юм.

Тэгэхээр зардлын тооцоог энэ хүргэн дуусгах нь зүйтэй байна.

²² <https://www.11-11.mn/index?p=about> Иргэд, олон нийттэй харилцах төв 11-11 албан ёсны цахим хуудас

ТАВ. ДҮГНЭЛТ

Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг дагалдан гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Хуулийн төслийн зохицуулах харилцааны онцлогоос хамааран тус төслөөр иргэнд хүлээлгэж буй үүрэг байгаа ч тус үүрэгтэй холбоотой иргэнд аливаа зардал үүсэхээргүй байна. Харин хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүрэгтэй холбоотой нэг хуулийн этгээд цахим гарын үсэг авахад 35 минут, мөн 5,365 төгрөг, үүн дээр нэмэлт зардал болох хуулийн этгээдийн цахим гарын үсгийн үнэ болох дундаж 35,000 төгрөг нэмэгдээд нийт 40,365 төгрөгийг зардал үүсэхээр байна.

Харин иргэн хуулийн этгээдийн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагад өргөдөл, гомдол гаргахтай холбоотой тусгайлсан зардлыг энэхүү тооцоогоор тооцоогүй болно.

Хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтанд үүрэг хүлээлгэсэн гол зохицуулалтуудыг шүүж үзэхэд 1995 онд УИХ-аас баталсан Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон 2022 онд УИХ-аас баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн зарим зохицуулалттай агуулгын хувьд ижил, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалтыг илүү тодорхой болгох, нарийвчлах зэргээр шинээр үүрэг үүсгээгүй тул тухайн зохицуулалт тус бүрт зардал тооцоогүй болно.

Харин хуулийн төслийн 14.8-д “Өргөдөл, гомдлын нэгдсэн системийн үйл ажиллагааг Иргэд олон нийттэй харилцах төв хариуцан зохион байгуулна.” Гэж заасан зохицуулалттай холбоотой судлаад үзэхэд өргөдөл гомдлын нэгдсэн систем нь одоо Иргэд олон нийттэй харилцах төв 11-11-д ашиглаж байгаа программ бөгөөд тус программд нэгдэж болох нийт 489 төрийн байгууллагаас 75 төрийн байгууллага тус системд нэгдсэн буюу энэхүү системийг шинээр хийх бус зөвхөн үлдсэн тарийн байгууллагыг нэгтгэж, илүү боловсронгуй болгох харилцаа үүсэх нь тодорхой болсон. Иймд тус зохицуулалттай холбоотой үүсэх зардлыг урьдчилан тооцох боломжгүй болсон юм.

Нэгтгэн дүгнэвэл урьдчилсан байдлаар хуулийн төслийн зардал, үр өгөөжийн харилцаа нь үр өгөөж нь зардлаасаа илүү байна гэж дүгнэлээ.

-----oOo-----